

Цэвэрлэгээ хийх, зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл угаах журам

2023



**БҮСҮЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙХ, ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ, ЦАГААН
ХЭРЭГЛЭЛ УГААХ ЖУРАМ**

Хувилбарын дугаар: 02

Хүчин төгөлдөр болсон огноо: 2023.10.17

Баримт бичгийн дугаар:02

Баримт бичгийг хариуцах нэгж	Нийт тасаг, албад		
Баримт бичгийн нууцлалын зэрэглэл:	Дотоод	Баримт бичгийн түвшин	3
		Албан тушаал	Гарын үсэг
Боловсруулсан:	Д.Баасанхүү	Үйлчилгээний албаны дарга	
Санал өгч хянасан:	Д.Баянмөнх	Үйл ажиллагаа хариусан дэд захирал	
Хянаж баталсан:	Г.Дашжанцан	БОЭТөвийн захирал	



Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл

№	Хувилбарын цуврал дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлтийг баталсан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга	Гарын үсэг
1	2	2023 оны 10сарын 17		ЭМС – ынЦэвэрлэгээ үйлчилгээ хийх 186,187 тоот тушаал өөрчлөгдөж , 2019 оны 11 сарын 29-ны 537 тоот тушаалын 6, 8 -р хавсралтыг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор шинэчлэгдсэн	
2					
3					
4					

АГУУЛГА.....

1.	ЗОРИЛГО.....	4
2.	ХАМРАХ ХҮРЭЭ.....	4
3.	НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГ, ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД.....	4
3.3	Холбоотой баримт бичгүүд	4
4.	ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА, ЭРХ МЭДЭЛ	4
5.	Цэвэрлэгээний ерөнхий зарчим	5
6.	Хагалгаатай болон халдварын эрсдэл өндөртэй А бүсэд цэвэрлэгээ хийх журам	6
7.	Халдварын эрсдэл дунд В бүсэд цэвэрлэгээ хийх журам	6
8.	Бага эрсдэлтэй С бүсэд хийх цэвэрлэгээний журам	6
9.	Ариун цэврийн өрөөнд тогтмол хийгдэх цэвэрлэгээний журам	7
10.	Палатанд тогтмол хийгдэх цэвэрлэгээний журам	8
11.	Тарианы өрөөнд их цэвэрлэгээ хийх журам	9
12.	Коридорт их цэвэрлэгээ хийх журам.....	9
13.	Цэвэрлэгээний үр дүнг үнэлэх,хянах.....	9
14.	Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг цэвэрлэх	10
15 .	ХАВСРАЛТ БОЛОН ХЯНАЛТЫН ХУУДАС	
-	Өвчтөний өрөөнд өдөр тутам хийгдэх цэвэрлэгээг үнэлэх хуудас.....	11
-	Ариун цэврийн өрөөнд өдөр тутам хийгдэх цэвэрлэгээг үнэлэх хуудас.....	12
-	Цэвэрлэгээний чанарт дотоод хяналт хийсэн хуудас.....	13,14
-	Ажилбарын өрөөнд хийгдэх цэвэрлэгээг үнэлэх хуудас.....	15
-	Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бүртгэлийн хуудас /А бүс/	16
-	Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бүртгэлийн хуудас /Вбүс/	17
-	Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бүртгэлийн хуудас /С бүс/	18
16.	Эмнэлгийн зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл угаах заавар	19
-	Нийтлэг үндэслэл	19
-	Угаалгын газарт тавигдах шаардлага.....	19
-	Ангилан ялгах, халдваргүйжүүлэх.....	20
-	Угаах, хадгалах	20

ЗОРИЛГО

Цэвэрлэгээ үйлчилгээг стандартын дагуу чанартай гүйцэтгэж, үйлчлүүлэгчдийн эрүүл цэвэр орчинд үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг стандартын түвшинд үзүүлэх

1. ХАМРАХ ХҮРЭЭ

БОЭТөвийн нийт үйлчлэгч нар дагаж мөрдөнө.

2. НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГ, ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД**а. Товчилсон үг:**

- СУА – Соёл үйлчилгээний алба
- СТХДЗ- Стратеги төлөвлөлт хариуцсан дэд захирал
- ХСХА- Халдвараас сэргийлэлт, хяналтын алба
- ЭТҮЧАБА- Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын алба
- ТЭ- Тасгийн эрхлэгч
- САЗ- Сувилахуйн арга зүйч
- ЭЗ- Эдийн засагч
- Нярав

3. ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧГҮҮД :

- ЭМС-ын 537 тоот тушаалын 6-р хавсралт
- ЭМС-ын 537 тоот тушаалын 8-р хавсралт

ДӨРӨВ. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА (RACI матриц)

Процессын үүрэг хариуцлагын матриц

Процесс	Хариуцах бүтэц, албан тушаалтан								
	Үйлчлэгч нар	СТХДЗ	СУА	ЭТҮЧАБА	ХСХА	ТЭ	САЗ	ЭЗ	Нярав
Цэвэрлэгээ үйлчилгээг хийх	R	I	AI	AI	ACI	CI	ACI		
Цэвэрлэгээ хийх хуваарь гаргаж батлуулах			R						
Цэвэрлэгээнд хяналт тавих , хяналтын хуудсаар үнэлэх			RI	RIC	RIC	RIC	RIC		
Цэвэрлэгээнд шаардлагатай эд зүйлийг захиалах, хангах	CI	RCA	RCI	CI		I	I	C	RCA
Цэвэрлэгээний материалыг хадгалах, халдваргүйжүүлэх	RA			I	ACI				
Цэвэрлэгээний талбайг А,В,С бүсээр ангилах цэвэрлэх	RA		ACI				RCI		

Цус болон биологийн шингэн асгарах үеийн иж бүрдэл, хэрэглээ	RA		ACI	I	CI	I			
--	----	--	-----	---	----	---	--	--	--

(R- гүйцэтгэх, A- хариуцах, C- хамтран ажиллах, I-мэдээлэлтэй байх

Нийтлэг үндэслэл:

1. БОЭТөвийн клиник албадуудын цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэлд энэ журмыг мөрдөнө.
2. Клиник албадууд байнгын тогтмол цэвэрлэгээ халдваргүйтгэл хийснээр эмнэлгийн цэвэрлэгээ, үйлчилгээний чанар дээшилнэ.
3. Эрүүл мэндийн байгууллагын нийт талбайг гадаад болон дотоод орчин гэж 2 ангилна.
4. Дотоод орчинд хамаарах талбайг тасаг, нэгжийн үйл ажилагаа, халдварын эрсдлийн зэргээр нь А, В, С бүсэд хуваан , тус бүрт нь тохирсон цэвэрлэгээг хийнэ.

Нэг : Цэвэрлэгээний ерөнхий журам

- 1.1 Цэвэрлэгээ хийх үед ахуйн хэрэглээний бээлий, хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөнө
- 1.2 Тасаг, албадын үйлчлэгч нар өдөр бүр ажил эхлэхээс өмнө хариуцсан гадна орчны цэвэрлэгээг 30 минутын өмнө хийсэн байна.
- 1.3 Хана, шал, бусад тавилга хэрэгсэл, эмнэлгийн тусламж үйлчилгээний тоног төхөөрөмжийн гадаргууг цэвэрлэхдээ тоос, бичил биетэн агаарт цацагдахаас сэргийлж, чийгтэй алчуураар арчиж цэвэрлэнэ.
- 1.4 Хамгийн дээд хэсэгт байрлаж буй зүйлсээс эхэлж дээрээс доош нь чиглэлтэй цэвэрлэгээг хийнэ.
- 1.5 Цэвэрлэгээ хийх явцад цэвэрлэгээний ус бохирдоход бичил биетнийг орчинд тараах эрсдэлтэй тул бохирдсон уусмалыг тухай бүрд нь солино.
- 1.6 Цэвэрлэгээний багаж хэрэгсэл, материалыг өөр тасаг , нэгжид ашиглах, хооронд нь сольж хэрэглэхийг хориглоно.
- 1.7 Их цэвэрлэгээг ЖЭЭТ, ТНТ, ЧХХЭНТ, Мэс засал гэмтлийн тасаг, мэс ажилбар хийдэг амбулаториуд , сүрьеэ, халдварт, цусны банк, сэхээн, ДОХ, БЗДХ-ын кабинетууд, гао тогоонд их цэвэрлэгээг 7 хоногт 1 удаа, бусад тасаг, амбулаториуд 14 хоногт 1 удаа хийх ба шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй хийнэ.
- 1.8 А бүсэд (Халдварын зэрэг өндөртэй) хамаарагдах талбайн цэвэрлэгээг халдваргүйжүүлэх уусмал, халдваргүйжүүлэгч, дараа нь угаагч нунтгийн уусмалаар бохирдсон тухай бүр өдөрт 3 аас доошгүй удаа цэвэрлэгээг хийнэ.
- 1.9 В бүсэд (Халдварын эрсдэл дунд) хамаарагдах талбайн цэвэрлэгээг халдваргүйжүүлэх уусмал, халдваргүйжүүлэгч, угаагч нунтгийн холимог уусмалаар бохирдсон тухай бүр өдөрт 2 –оос доошгүй удаа цэвэрлэгээг хийнэ.
- 1.10 С бүсэд (Халдварын эрсдэл бага) угаалгын нунтаг бүхий уусмалаар өдөр тутамдаа цэвэрлэгээг хийнэ.
- 1.11 Цэвэрлэгээнд хэрэглэгдэх материалыг өнгөөр, ялгаж хэрэглэнэ.
 - Ариун цэврийн ерөөний суултуурт улаан өнгө
 - Ариун цэврийн ерөөний гар угаалтуур болон бусад гадаргууг шар өнгө
 - Үйлчлүүлэгчийн палат, ерөөнүүдийн тоног төхөөрөмж, хэрэгслүүд, хана, ор цонхыг цэнхэр өнгөөр
 - Шалны зориулалтын алчуурыг цагаан өнгийн алчуураар тэмдэгжүүлсэн байна.

- 1.12 Цэвэрлэгээнд хэрэглэсэн материалыг хэрэглэсний дараа халдваргүйжүүлж, угаалгын нунтаг бүхий уусмалаар угааж, цэвэр усанд зайлж дэлгэж хатаасан байна.
- 1.13 Цэвэрлэгээ хийх давтамж, цэвэрлэгээний материалыг цэвэрлэх, хадгалах, цэвэрлэгээ хийх уусмалыг бэлтгэх талаар суралт зохион байгуулах ба цэвэрлэгээний материалыг хадгалах тусдаа өрөөтэй байна.

Хоёр. Хагалгаатай болон халдварын эрсдэл өндөртэй А бүсэд цэвэрлэгээ хийх журам

- 2.1 А Бүсэд тусгаарлах, мэс засал, төрөх, боолт, тарианы, ариутгал, цусны банк, лаборатори, сүрьеэ, халдварт, амбулаторийн ажилбарын угаалгын бохирын хэсэг, сэхээн амьдруулах, эрчимт, төрсний болон мэс заслын дараах, нярай, ариун цэврийн өрөө орно.
- 2.2 Тухайн өдрийн мэс засал эхлэхийн өмнө тоног төхөрөөмж, тавилга, өрөөний гэрэл, соруулах хэсэг, мэс заслын ширээ, гэрэл ойлгогч бусад багаж хэрэгсэл, өрөө тасалгааны талбайг угаалгын нунтаг бүхий уусмалаар угааж халдваргүйжүүлэн мэс засал эхлэхээс 1 цагийн өмнө дуусгасан байна.
- 2.3 Мөн дээрх эд зүйлсийг мэс заслын хагалгаа дууссаны дараа халдваргүйжүүлж, угаалгын нунтаг бүхий уусмалаар угааж цэвэрлэнэ.
- 2.4 Хагалгаатай тасгуудын шалыг өдөрт 3 удаа, өвчтөний өрөөний хаалгыг өдөрт 2 удаа, таазыг сард 2 удаа өдөр бүр цэвэрлэнэ.
- 2.5 Тасаг нэгжид орох хаалга, хаалганы бариул, гэрлийн унтраалга, толь, хогийн сав, өвчтөн зөөвөрлөх тэргэнцэр, лифт зэргийг өдөр тутамдаа угааж цэвэрлэнэ.
- 2.6 Ариун цэврийн суултуур, гар угаалтуурыг өдөрт 3 удаа, цэвэрлэгээний багаж хэрэгслийг хэрэглэсний дараа угааж цэвэрлэнэ.
- 2.7 Цонхны гадна талыг сард 1 удаа, дотор тал, дулааны халаагуурыг (Радиатор), толийг өдөр тутамдаа, агааржуулалтын сараалж нүхийг долоо хоногтоо 1 удаа угааж цэвэрлэнэ.
- 2.8 Хагалгааны болон ажилбарын өрөөнүүд, багаж хэрэгслүүд, тавилга хэрэгсэл болон бусад бохирдсон гадаргууг халдваргүйтгэлийн уусмалаар 2 цаг тутамдаа халдваргүйтгэнэ.

Гурав. Халдварын эрсдэл дунд В бүсэд цэвэрлэгээ хийх журам

- 3.1 В бүсэд Гал тогоо, амбулаторийн ажилбарын бус өрөөнүүд, эмийн сан, эмчийн өрөө, физик эмчилгээ, сувилагчийн пост, рентген, хэт авиан оношилгоо, зүрхний бичлэг, угаалгын газар, төрөхийн болон мэс заслын өмнөх, цус цуглуулах өрөөнүүд орно.
- 3.2 Шалыг өдөрт 2 удаа, таазыг сард 1 удаа, цонхны гадна талыг сард 1 удаа, цонхны дотор тал, дулааны халаагуур радиатир, агааржуулалтын сараалж нүхийг долоо хоногт 1 удаа угааж цэвэрлэнэ.
- 3.3 Тасаг нэгжид орох хаалга, өвчтөний өрөөний хаалга, бариул, гэрлийн унтраалга, толь, өдөр тутамдаа угааж цэвэрлэгээ хийнэ.
- 3.4 Гар угаалтуур, ариун цэврийн суултуурыг өдөрт 2 удаа, хогийн сав, цэвэрлэгээний багаж хэрэгслийг хэрэглэсний дараа өдөр тутамдаан цэвэрлэнэ.

Дөрөв. Бага эрсдэлтэй С бүсэд хийх цэвэрлэгээний журам

- 4.1 С бүсэд захиргаа, сургалтын өрөө, хонгил, хүлээлгийн өрөө, бүртгэл, өлгүүр г.м
- 4.2 Шал, хаалганы бариул, гэрлийн унтраалга, гар угаалтуур, ариун цэврийн суултуур, хогийн сав зэргийг өдөр тутамдаа цэвэрлэнэ.
- 4.3 Цонхны гадна талыг улиралд 1 удаа, цонхны дотор тал, толийг долоо хоногт 1 удаа, дулааны халаагуур, агааржуулалтын сараалж нүхийг сард 1 удаа цэвэрлэнэ.
- 4.4 Ариутгалын бодис хэрэглэхдээ амны хаалт, резинэн бээлий өмсөнө.

Тав. Ариун цэврийн өрөөнд тогтмол хийгдэх цэвэрлэгээний журам

Зорилго: Эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм сахих, өвчтөний болон үйлчлүүлэгчдийн ая тухтай байдал, тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг хангах
Цэвэрлэгээ хийх заалт:

- 15-20 минут тутамд мөн бохирдсон тохиолдол бүрт цэвэрлэнэ.

Хэрэглэгдэх зүйлс:

- Тэмдэгтэй хувин 2 ширхэг
- Тэмдэгтэй алчуур 3 ширхэг, шалны мод
- 0,06% жавелионы уусмал
- Өнгөлөгч
- Цэвэрлэгээний бээлий
- Маск
- Суултуур угаах сойз
- Угаалгын нунтаг, вок, саван

Үйлдлийн технологи

1. Тааз, чийдэнгийн бүрхүүл, агааржуулалтын хэсэг, хаалганы дээд ирмэг зэргийг бүлээн усаар савандаж угаана.
2. 00-ийн өрөөний хана, хаалгыг савантай усаар угаана.
3. 00-ийн өрөөний суултуурыг угаахдаа савантай усаар, суултуурын гадна талыг сайтар угааж, дараа нь дотор талыг сойздож угаана.
4. 00-ийн өрөөний шал, шалны ирмэгийг сойздож савандаж угаана.
5. Дээрхи үйлдлийг 0,03% жавелионы уусмалаар дахин угаана.
6. Хогийн савны дотор талыг савандаж угаахын зэрэгцээ 0,03 % жавелионы уусмалаар зайлж, бохир хог хаягдлыг агуулах цэвэр ууцыг савны дотор талыг бүрж тавина.
7. Бүх цэвэрлэгээ хийж дууссаны дараа 5-10% -ийн хлорын шохойн сүүн уусмал, аль эсвэл 0,06% ийн Жавелионы уусмалаас 200-300 мл суултуурт хийнэ.
8. Үйлдлийг хийж дууссаны дараа 0,03 % жавелионы уусмалаар бээлийгээ угаана.
9. Бээлийг тайлсны дараа гараа дахин угаана.

Анхаарах зүйл:

- 00-ийн өрөөнд цэвэрлэгээ хийхдээ маск шаардлагатай тохиолдолд хормогч өмсөнө.
- Ариун цэврийн өрөөнд цэвэрлэгээ хийхдээ суултуурыг улаан өнгийн тэмдэгтэй алчуур, шалыг цагаан өнгийн алчуураар арчиж цэвэрлэнэ.
- Халдваргүйтгэлийн бодисын хэрэглэх заавар, тун хэмжээний стандартыг мөрдөнө.

Зургаа .Палатанд тогтмол хийгдэх цэвэрлэгээний журам

Зорилго: Өвчтөнийг цэвэр тохилог орчинд байлгах, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм сахих.

Цэвэрлэгээ хийх заалт: Цэвэрлэгээг өдөрт 2 -аас доошгүй удаа цэвэрлэнэ

Хэрэглэгдэх зүйлс:

1. Тэмдэгтэй хувин 2 ширхэг /цэвэр, савантай ус/
2. Тэмдэгтэй алчуур 3 ширхэг, шалны мод
3. 0,015% жавелионы уусмал
4. Өнгөлөгч
5. Цэвэрлэгээний бээлий
6. Тоосны алчуур

7. Угаалгын нунтаг, вок, саван

Үйлдлийн технологи

1. Цэвэрлэгээ хийхээс өмнө үйлчилүүлэгчид тайлбарлана.
2. Тааз, чийдэнгийн бүрхүүл, агааржуулалтын хэсэг, хаалганы дээд ирмэг зэргийг бүлээн усаар савандаж угаана.
3. Дараа нь цонхны рам, тавцан, шил, хана зэргийг савантай бүлээн усаар угаана.
4. Палатны шалыг угаахдаа эхлээд ирмэгийг нь савантай бүлээн усаар савандаж сойздож угаагаад шалаа угаана.
5. Дээрхи бүх үйлдлийг давтан 0,015% жавелионы уусмалаар угааж арчина.
6. Толь тавиур угаалтуур зэргийг өнгөлөгчөөр өнгөлнө.
7. Хогийн савны дотор талыг савандаж угаахын зэрэгцээ 0,015% жавелионы уусмалаар зайлж тавина.

Анхаарах зүйл

1. Палатанд цэвэрлэгээ хийхдээ ижил өнгийн зүйлээр тэмдэг тавьсан шалны мод, шалны алчуур, хувинтай байна.
2. Хүнд болон хэвтрийн өвчтөний палатыг цэвэрлэхдээ өвчтөний ая тухыг алдагдуулахгүй аль болох түргэн шуурхай цэвэрлэх..

Долоо. Тарианы өрөөнд их цэвэрлэгээ хийх журам

Зорилго: Эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм сахих, цэвэр орчинд эмчилгээ үйлчилгээ явуулах

Цэвэрлэгээ хийх заалт: Өдөрт 3 удаа буюу бохирлогдсон тохиолдол бүрд цэвэрлэнэ.

Хэрэглэгдэх зүйлс:

- Тэмдэгтэй хувин 2 ширхэг
- Сойз
- Тэмдэгтэй алчуур 3 ширхэг, шалны мод 0,015% жавелионы уусмал
- Өнгөлөгч
- Цэвэрлэгээний бээлий
- Тоосны алчуур
- Угаалгын нунтаг, саван

Үйлдлийн технологи:

1. Тарианы өрөөнд байгаа эд хэрэглэл, эмийн шкаф, тэргэнцэр, тариурын сав зэргийг хөдөлгөж цэвэрлэгээг чанартай хийнэ.
2. тааз, чийдэнгийн бүрхүүл, агааржуулалтын хэсэг, хаалга, хаалганы дээд ирмэг, ХАНА, зэргийг бүлээн усаар савандаж угаана.
3. Шалыг угаахдаа эхлээд ирмэгийг нь савантай бүлээн усаар савандаж сойздож угаагаад шалаа угаана.
4. Дээрхи бүх үйлдлийг давтан 0,015% жавелионы уусмалаар угааж арчина..
5. Хогийн савны дотор талыг савандаж угаахын зэрэгцээ 0,015% жавелионы уусмалаар зайлж цэвэр уутыг савны дотор талыг бүрж тавина

Анхаарах зүйл:

Зөвхөн тарианы өрөөнд зориулсан ижил өнгийн зүйлээр тэмдэг тавьсан шалны мод, шалны алчуур, сойз, хувинтай байна.

Ёс . Коридорт их цэвэрлэгээ хийх журам

Зорилго: Үйлчлүүлэгчдийн тав тухтай орчныг бүрдүүлэх

Цэвэрлэгээ хийх заалт: 7-14хоногт 1 удаа их цэвэрлэгээ хий

Хэрэглэгдэх зүйлс:

1. Тэмдэгтэй хувин 2 ширхэг
2. Тэмдэгтэй алчуур 2 ширхэг, шалны мод

3. 0,015% жавелионы уусмал
4. Өнгөлөгч
5. Цэвэрлэгээний бээлий
6. Тоосны алчуур
7. Угаалгын нунтаг, вок, саван
8. Маск
9. Сойз

9.1 Үйлдлийн технологи:

1. Коридорын тааз, чийдэнгийн бүрхүүл, агааржуулалтын хэсэг, хананы тоосыг буулгаж арчина.
2. Дараа нь цонхны тавцан, шил, хана, шүүгээ, ширээ, сандал бусад эд хогшил зэргийг савантай бүлээн усаар угаана.
3. Цонхны шилийг бүлээн цэвэр устай алчуураар арчаад, цэвэр хуурай алчуураар хаттал нь арчина.
4. Ханыг угаахдаа дээрээс нь доош нь савандаж угаана.
5. Шалыг угаахдаа эхлээд ирмэгийг нь савантай бүлээн усаар савандаж сойздож угаагаад шалаа угаана.

6. Дээрхи бүх үйлдлийг давтан 0,015% жавелионы уусмалаар угааж арчина
Арав. Асгарсан, цацагдсан цус, бусад органик материалыг цэвэрлэх

Эрүүл мэндийн ажилтан асгарсан, цацагдсан цус, биологийн шингэн асгарсан тохиодолд ажилтан, үйлчлүүлэгчдийг халдвар, гэнэтийн ослоос сэргийлж цаг тухайд нь асгарсан шингэнийг цэвэрлэх иж бүрдэлийг ашиглан халдваргүйжүүлэн цэвэрлэнэ.

Асгарсан шингэнийг цэвэрлэх иж бүрдэл нь тусламж, үйлчилгээ үзүүлж буй цэг бүрт байна.

Асгарсан цус, биологийн шингэн, бусад органик материалыг халдваргүйжүүлж цэвэрлэх иж бүрдэлд нэг удаагийн хэрэглээний бээлий, мэс заслын амны хаалт, хормогч, нүдний шил, нүүрний хамгаалалт, ус нэвтрэхгүй хог хаягдлын уут, шингээгч цаас, угаалгын нунтаг, халдваргүйжүүлэх бодис, хогийн хутгуур эсвэл картон цаас зэрэг байна.

- Хувийн хамгаалах хэрэгслийг өмсөнө.
- Нэг удаагийн шингээгч цаас, даавуугаар угаалгын нунтаг бүхий уусмал хэрэглэж арчиж , хатаана.
- Бохирдсон материалыг хог хаягдлын саванд хийнэ.
- Гарын эрүүл ахуйг сахина.

Жижиг асгаралт /диаметр 10см-ээс бага/

- Хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөнө.
- Асгарсан шингэн дээр халдваргүйжүүлэх бодис /Жавелионы 0,06% /шингээж тодорхой хугацааны дараа нэг удаагийн шингээгч цаасаар цэвэрлэнэ.
- Халдваргүйжүүлэгч бодистой угаалгын нунтаг бүхий уусмалаар гадаргууг арчиж хатаана.
- Бохирлогдсон материалыг ус нэвтрэхгүй халдвартай хог хаягдлын уутанд хийнэ.
- Гарын эрүүл ахуйг сахина.

Их хэмжээний асгаралт /диаметр нь 10см-ээс их/

- Хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөнө.
- Асгарсан цус биологийн шингэн цэвэрлэх нэг удаагийн шингээгч цаас , сав, хутгуур эсвэл картон цаас ашиглан материалыг ашиглана.

- Асгарсан шингэн дээр халдваргүйжүүлэх бодис /Жавелионы 0,06% /шингээж тодорхой хугацааны дараа нэг удаагийн шингээгч цаасаар цэвэрлэнэ.
- Халдваргүйжүүлэх бодистой угаалгын нунтаг бүхий уусмалаар гадаргууг арчиж хатаана.
- Бохирлогдсон материалыг ус нэвтрэхгүй халдвартай хог хаягдлын уутанд хийнэ.
- Гарын эрүүл ахуйг сахина

Арван нэг. Цэвэрлэгээний үр дүнг үнэлэх,хянах

Тухайн байгууллагын нийлбэр онооны хувь **60%**-аас бага байвал хангалтгүй, **60-70%** бол дундаас доогуур, **71-90%** дундаж, **91-100%** байвал хангалттай түвшинд байна гэж үнэлээд холбогдох арга хэмжээ авч ажиллана.Доорхи шалгуур хуудсаар үнэлгээг хийнэ.

Захирлын 2023 оныдугаар сарынны
өдрийн тоот тушаалын хоёрдугаар
хавсралт

1. Өвчтөний өрөөнд өдөр тутам хийгдэх цэвэрлэгээг үнэлэх хуудас

Тасаг : _____ Дотоод хяналт хийсэн огноо: /..... //.... /

№	Цэвэрлэгээний шалгуур	Палат №		Палат №		Палат №		Палат №	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1.Өдөр тутмын цэвэрлэгээнд шаардлагатай зүйлс									
1	Бээлий								
2	Халдваргүйжүүлэх ажлын уусмал бэлдсэн эсэх хэрэглээ								
3	Угаалгын нунтаг								
4	Халтирахаас сэргийлсэн анхааруулга								
5	Спиртэнд суурьтай гар халдваргүйжүүлэх								
2. Бохирдох эрсдэл өндөр буюу хүрэлцэх давтамж их гадаргуу									
6	Хаалганы бариул халдваргүйжуулсан эсэх /2 цаг тутамд/								
7	Хаалга								
8	Цонхны тавцан								
9	Ханан дээрх толбыг халдваргүйжүүлэх уусмалаар арчсан эсэх								
10	Гэрлийн унтраалга								
11	Угаалтуур								
12	Тавилга хөдөлгөж цэвэрлэсэн эсэх								
13	Шал								
14	Агааржуулалтын хоолойг арчиж цэвэрлэсэн эсэх								
15	Хогийн савны цэвэрлэгээ								
16	Хогийн шүүр, хогийн тосгуур цэвэрлэсэн эсэх								
17	Цэвэрлэгээний материалын алчуурын ангилал, хадгалалт								
16	Хог хаягдалаа устгасан эсэх								
17	Эргэлтийн хаалганы шат цэвэрлэсэн эсэх								
18	Цэвэрлэгээ хийсэн тэмдэглэл хөтөлсөн эсэх								
	Дүн								

Хянасан

Үйлчлэгч

2. Ариун цэврийн өрөөнд өдөр тутам хийгдэх цэвэрлэгээг үнэлэх хуудас
Дотоод хяналт хийсэн огноо: /..... //..... //..... /

№	Цэвэрлэгээний шалгуур	Тасаг		Тасаг.....		Тасаг.....		Тасаг	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1.Өдөр тутмын цэвэрлэгээнд шаардлагатай зүйлс									
1	Бээлий								
2	Халдваргүйжүүлэх ажлын уусмал бэлдсэн эсэх , хэрэглээ /огноо/								
3	Угаалгын нунтаг								
4	Халтирахаас сэргийлсэн анхааруулга								
5	Спиртэнд суурьтай гар халдваргүйжүүлэх								
2. Бохирдох эрсдэл өндөр буюу хүрэлцэх давтамж их гадаргуу									
6	Хаалганы бариул халдваргүйжуулсан эсэх /2 цаг тутамд/								
7	Хаалга								
8	Ханан дээрх толбыг халдваргүйжүүлэх уусмалаар арчсан эсэх								
9	Гэрлийн унтраалга								
10	Угаалтуур								
11	Тавилга хөдөлгөж цэвэрлэсэн эсэх								
12	Шал								
13	ОО –д хийх Халдваргүйжүүлэх уусмал бэлдсэн эсэх / огноо /								
14	Хогийн савны цэвэрлэгээ								
15	Хогийн шүүр, хогийн тосгуур цэвэрлэсэн эсэх								
16	Цэвэрлэгээний материалын алчуурын ангилал, хадгалалт								
17	Хог хаягдалаа устгасан эсэх								
18	Цэвэрлэгээ хийсэн тэмдэглэл хөтөлсөн эсэх								
	Дүн								

Хянасан

Үйлчлэгч

3. Цэвэрлэгээний чанарт дотоод хяналт хийсэн хуудас

Дотоод хяналт хийсэн огноо: /..... //..... //... ./

Цэвэрлэгээ хийх талбай	№	Цэвэрлэгээний шалгуур:												
Нэг. Барилга байгууламжийн хэсгийн цэвэрлэгээ														
Хана, цонхны хүрээ, тааз	1	Хана, таазны дотор тал нь тоосгүй, толбогүй бохирдолгүй байх												
	2	Гэрлийн бүрхүүл, гэрлийн унтраалга тоосгүй цэвэр байх												
Цонхны дотор тал	3	Шилний гадаргуу, хүрээ, тавцан нь хурууны мөр болон бусад бохир, халтар толбогүй цэвэрхэн байх												
Хаалга	4	Хаалганы дотор болон гадна тал, хаалганы хүрээ нь тоос шороогүй, бохирдолгүй цэвэрлэгдсэн байх												
Шал	5	Шал, шалны хүрээ, булан тохой нь тоос шороогүй, бохир толбогүй, цаас болон хог хаягдал хаяагүй, ус болон шингэн асгараагүй байх												
	6	Цэвэрлэж буй нойтон шалан дээр явган хүн болгоомжтой явах талаар тэмдэглэгээ тавих												
Агааржуулалтын нүх	7	Агааржуулах нүх, агааржуулалтын хэсэг нь тоос шороогүй, бохир толбогүй												
Хоёр. Тавилга хэрэгслийн цэвэрлэгээ														
Цахилгаан хэрэгсэл	8	Цахилгаан хэрэгсэл, цахилгааны утас нь тоос шороогүй цэвэрхэн байх												
Тавилга	9	Тавилга тавиур, ширээ сандал, хувцасны шүүгээний гадаргуу нь толбо, өнгөргүй, бусад юм асгаагүй байх												
	10	Тавилгын хөл, дугуйн хөлнүүд, тавилгын булан тохой, хүрээ завсар нь бохир толбогүй, тоос шороогүй байх												
Ариун цэврийн хэрэгсэл	11	Шаазан болон хуванцар гадаргуутай суултуур бүрэн, гэмтэлгүй, зэв үүсээгүй, бохир ямар нэг толбогүй, өнгөргүй, өтгөнөөр бохирлогдоогүй байна.												
	12	Ариун цэврийн өрөөний хана цэвэр бохирлогдоогүй байх												
	13	Ус дамжуулах хоолойнууд нь тоосгүй байх												
	14	Ариун цэврийн өрөөний хог хаягдлын сав нь цэвэр, гэмтэл хагаралгүй байх												

Гурав. Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ									
Өвчтөнд хэрэглэгдэх тоног төхөөрөмж	15	Өвчтөнд хэрэглэгдэх тоног төхөөрөмж нь цус болон биологийн шингэнээр бохирлогдоогүй, ямар нэг толбогүй байх ,							
	16	Тоног төхөөрөмжийн хөл болон дугуйн хөлнүүд нь тоос шороогүй , ямар нэг толбо үүсээгүй байх							
Цэвэрлэгээний тоног төхөөрөмж	17	Цэвэрлэгээний материалыг өнгөөр ялгасан байна. Өрөө бүр тусдаа алчууртай байх							
	18	Цэвэрлэгээний бодис, хэрэгсэл хангалттай байх / угаалгын нунтаг, халдваргүйжүүлэх уусмал, ахуйн бээлий гм /							
	19	Цэвэрлэгээний тэргэнцэртэй байх							
	20	Цэвэрлэгээний материал хадгалах өрөөтэй байх , тоос шороогүй асгарсан шингэнгүй байх							
	21	Цус биологийн шингэн асгарсан үед хэрэглэх цомогтой байх , хэрэглэж хэвшсэн байх							
	22	Эргэлтийн хаалга, 2 талын шат цэвэрлэсэн эсэх							
	23	Цахилгаан шат цэвэрлэсэн эсэх							
	24	Гадна орчны цэвэрлэгээг өдөр бүр хийсэн байх, хоггүй байх							
	25	Цэвэрлэгээ хийсэн тэмдэглэл хөтөлсөн эсэх							
Нийт оноо									

Хянасан Үйлчлэгч

4. Ажилбарын өрөөнд хийгдэх цэвэрлэгээг үнэлэх хуудас

Тасаг : _____ Өрөөний дугаар _____ Хяналт хийсэн огноо:

№	Цэвэрлэгээ хийх талбай								
Өдрийн ажилбар эхлэхийн өмнөх цэвэрлэгээ (Ажилбарын үед хүрч болзошгүй гадаргуугийн тоосыг дээрээс доош чиглэлд арчина.)									
1	Тавилга								
2	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөл								
Үйлчлүүлэгч хооронд									
4	Гарын эрүүл ахуй сахина.								
5	Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх								
Хүрэлцэх давтамж их гадаргуугийн цэвэрлэгээ									
5	Хаалганы бариул хэрэгсэл арчиж цэвэрлэсэн эсэх								
6	Шал болон хана (хэрвээ цус биологийн шингэн цацарсан асгарсан бол)								
7	Хувийн хамгаалах хувцас								
8	Ариутгалын бодис хэрэглэсэн эсэх								
Өдрийн ажилбар дууссаны дараах эцсийн цэвэрлэгээ, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт :									
9	Гэрлийн унтраалга								
10	Гар угаалтуур								
11	Шал								
12	Хог хаягдал цуглуулах сав								
13	Цэвэрлэгээ хийсэн тэмдэглэл хөтөлсөн эсэх								
	Нийт дүн								

Хянасан :

Үйлчлэгч :

10. А,В,С бүсийн цэвэрлэгээг хийсэн тэмдэглэл хөтлөх хуудас

1. Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бүртгэлийн хуудас /А бүс/ 2023

Захирлын 2023 оныдугаар сарынны
өдрийн тоот тушаалын гуравдугаар
хавсралт

**Арван хоёр. ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ, ЦАГААН ХЭРЭГЛЭЛ
УГААХ, ХЭРЭГЛЭХ ЗААВАР
Нийтлэг үндэслэл**

- 1.1 Угаалгын газар бохир хэрэглэлийг ангилан ялгах, халдваргүйжүүлэх, угаах, индүүдэх, цэвэр хэрэглэлийг хадгалах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
- 1.2 Халдваргүйжүүлэлт, угаалга нь бичил биетний тоог бууруулдаг, халуун индүүгээр индүүдэх нь бичил биетнийг устгадаг тул индүүдэхдээ тасаг, нэгжид хийхгүй угаалгын газарт хийнэ.
- 1.3 Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчийн ая тухтай байдлыг хангах цэвэрхэн, өнгө үзэмжтэй цагаан хэрэглэлээр хангагдсан байна.
- 1.4 Мэс засал, төрөх, сэхээн амьдруулах, тусгаарлах, халдварт, сүрьеэгийн тасагт хэвтэн эмчлүүлэгсдийг эмнэлгээс цагаан хэрэглэлээр хангана гэрээс авчруулж хэрэглэхгүй. Бусад тасагт үйлчлүүлэгч өөрөө хүсвэл цагаан хэрэглэлээ авчирч хэрэглэж болох ба эмнэлгээс гарахад нь угааж, халдваргүйжүүлэх зааврыг өгнө.
- 1.5 Үйлчлүүлэгчийн цагаан хэрэглэлийг бохирдсон тохиолдол бүрт солино.

Хоёр. Угаалгын газарт тавигдах шаардлага

- 2.1 Угаалгын газар нь нэг чиглэлийн урсгалтай, бохир, цэвэр хэсэгтэй байна. Бохир хэсэгт бохир хэрэглэлийг ангилан ялгах, угааж халдваргүйжүүлэх, цэвэр хэсэгт индүүдэх, хадгалах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
- 2.2 Угаалгын газрын өрөө тасалгаа нь гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, цэвэр, бохир усны шугамд холбогдсон, зөөврийн усан хангамжтай үед угаалгын үйлчилгээнд хүрэлцэхүйц хэмжээний ус нөөцлөх савтай, ус зөөвөрлөх, халаах хэрэгслээр хангагдсан байна.
- 2.3 Угаалгын газрын өрөөний шал нь резинэн хулдаас, ус зайлуулах хоолойтой, хана нь шаазан хавтан, таазыг эмүльсдсэн байна. Шал—хана, тааз-ханын хийц материал нь цайвар өнгөтэй, цэвэрлэхэд тохиромжтой, зай завсаргүй, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.
- 2.4 ЭМА-ны ажлын хувцас, нярай, мэс засал, төрөхийн цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийг тус, тусад нь, бусад тасгийн цагаан хэрэгслийг халдварын эрсдэл өндөртэй (халдварт, сүрьеэгийн тасаг, олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай үйлчлүүлэгчийн, цус, шээс, гэх мэт биологийн шингэнээр бохирлогдсон), халдварын эрсдэл багатай гэж ангилж угаана.

Гурав. Ангилан ялгах, халдваргүйжүүлэх

- 3.1 Ор хөнжлийн даавуу, дэрний уут, гудас, матрасны гаднах уутыг үйлчлүүлэгч эмнэлгээс гарах болон бохирдсон тохиолдол бүрт цэвэр хэрэгслээр солиж бохир хэрэгслийг угаалгад өгнө.
- 3.2 Үйлчлүүлэгчийн орноос бохир цагаан хэрэглэлийг авахдаа орчинд бохирдлыг тараахаас сэргийлж хуйлах, эвхэх байдлаар авна.
- 3.3 Гудас, матрас нь эмнэлгийн зориулалттай гаднах өнгө нь ус нэвтэрдэггүй бол тасагт нь халдваргүйжүүлж, угааж болно.

- 3.4 Хөнжил, бүтээлэг зэрэг зөөлөн эдлэлийг угаалгын газарт өгч халдваргүйжүүлж, угаалгана.
- 3.5 Хөвөнтэй, угаахад тохиромжгүй материалаар хийгдсэн хөнжил, гудас, матрас, дэрийг биологийн шингэнээр бохирлогдоогүй бол дезкамерт халдваргүйжүүлэлт хийнэ.
- 3.6 Тасаг, нэгж бүр бохир хэрэгслийг зөөвөрлөх үс нэвтэрдэггүй зориулалтын уут, тэргэнцэртэй байна. Даавуун уут хэрэглэж байгаа тохиолдолд уут нь бариултай байх ба зөөвөрлөх ажилтан бээлий өмсөнө.
- 3.7 Бохир хэрэгслийг уутанд дүүргэж хийхгүй s хүртэл хэмжээгээр хийнэ. Бохир хэрэгслийг зөөвөрлөж байгаа уут нь цэвэр хэрэгслийн уутнаас өнгөөр ялгасан байна. Уутыг угааж, халдваргүйжүүлж, индүүднэ.
- 3.8 Бохир хэрэгслийг тасаг, нэгжээр нь бүртгэн хүлээн авч бохирдолтын байдлаар нь халдвартай үйлчлүүлэгчийн, биологийн шингэнээр бохирлогдсон, хир ихтэй гэх мэтээр ангилан угаалгад шилжүүлнэ.
- 3.9 Бохир хэрэгсэлтэй ажиллаж байгаа ажилтан нүдний салст хамгаалах нүдний шил, нүүрний хаалт, амны хаалт, усанд тэсвэртэй бээлий, халад, хулдаасан хормогч, ханцуйвчаар хангагдсан, хэрэглэж хэвшсэн байна.

Дөрөв. Угаах, хадгалах

- 4.1 Угаалганд эмнэлгийн зориулалттай халдваргүйжүүлэх үйлчилгээтэй угаалгын бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж хэрэглэнэ.
- 4.2 Халдваргүйжүүлэх үйлчилгээгүй ахуйн зориулалтын угаалгын бодис хэрэглэж байгаа үед бохир хэрэгслийг эхэлж халдваргүйжүүлсний дараа угаана. Халдваргүйжүүлэх бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж, хэрэглэнэ.
- 4.3 Хагас автомат угаалгын машин болон гараар угааж байгаа тохиолдолд мушгиж, сэгсэрсний дараа цэвэр усаар угаалгын бодисын үлдэгдлийг арилтал угаана.
- 4.4 Угаах хэрэгслийн халдварын эрсдлээс шалтгаалан эрсдэл багатайгээс эхэлж угаана. Угаалга хооронд машин, савны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийж дараагийн хэрэгслийг угаана.
- 4.5 Угаалгаас гарсан хэрэгслийг халуун агаараар хатаах төхөөрөмжийг ашиглан хатаахаас гадна нарны гэрэлд хатааж болно.
- 4.6 Цэвэр хэрэгслийг шалнаас дээш **10-15** см өргөгдсөн, хангалттай хэмжээний тавиур бүхий шүүгээнд хадгална.
- 4.7 Цагаан хэрэгслийг зориулалтын уутанд багцалж савлана. Цэвэр хэрэгслийг тасаг нэгж рүү зөөвөрлөх уут тусдаа байна.